

МОНГОЛ ЭМ СҮГМЭЛ-7-ИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

Тун шан^{1,2}. Мандах¹. Цэнд-аюуш Д². Энхцэцэг Ж². Ванхуан³.
Өвөр монголын үндэстэний их сургуулийн хараат эмнэлгийн хороо¹, Тунляо 028000
Монгол Улсын АШУУИС²
Өвөр монголын үндэстэний их сургуулийн монгол эм эмнэлгийн дээд сургууль³,
Тунляо 028000, Email: tongshan100@.163.com

OVERVIEW OF STUDY TRADITIONAL MONGOLIAN PRESCRIPTION SUGMEL-7

Tongshan^{1,2}, Mandax¹, Tsend-ayush D², Enkhtsetseg J², Wanghuan³
Affiliated hospital of Inner Mongolia University for the nationalities¹,
Tongliao 02800, China
Mongolian Medicine International school of MNUMS², Ulaanbaatar-14210, Mongolia
Mongolian Medicine School of Inner Mongolia University for the nationalities³,
Tongliao 02800, China e-mail: tongshan100@.163.com

Abstract

This article included overview of study of Traditional Mongolian prescription Sugmel-7.

The uses of traditional medicine Sugmel-7 collected by Classic books of Mongolian traditional medicine, Prescription of Mongolian traditional medicine textbooks. Overview modern medicine study of Sugmel-7 searched by online Chinese fund of knowledge, research materials of Inner Mongolian University of nationalities. It would be provided traditional prescription Sugmel-7 future study clarification.

Key words: Traditional Mongolian prescription sugmel-7; Overview of study;

Товчлол

Монгол эм найрлага Сүгмэл-7-ийн уламжлалт хэрэглээг Монгол анагаах ухааны сурвалж бичиг, Монгол анагаах ухааны эм найрлагын судлал зэрэг ном материалаас эрж, одоогийн судалгааны талаар Дундад улсын цахим сүлжээ, Дундад улсын Монгол эм эмнэлэг, Өвөр монголын үндэстэний их сургуулийн эрдэм шинжилгээний материалыг хайж шинжилж дараагийн судалгаанд хяналт болгохын тусад тус өгүүллийг эмхэтгэв.

1. Монгол эм сүгмэл-7-ийн сурвалж бичиг дэх дүгнэлт

Монгол эм найрлага Сүгмэл-7-ийн өөр нэрс нь төлжүүлэгч сүгмэл-7, сүгмэлжингор гэдэг. Энэ найрлагын бүрэлдэхүүнд сүгмэл 150гр, цагаан хор, эрхтэний гар, хэрээний нүд, задь, голт бор, хар агар тус бүр 25 гр зэрэг 7 хөл эмээс бүрэлдэнэ. Эдгээрийг нарийн талхдаж, талхаар хэрэглэнэ. Хийг дарах, тамиржуулах

чадалтай. Эмчилгээнд бөөр зүрхний хий бүрэлдсэн өвчин, хийгээр сарын хир тэгшгүй болох, давсаг шархирах, хөл нуруу өвдөх, цагаанчийг элбэгших, тамирдах, бие хүндрэхэд хэрэглэдэг. Тус найрлага нь бүлээн чанартай. Үүнд гошгуун амттай, бүлээн чанартай, тослог эрдэм бүхий илчийг сэлбэх, хийг дарах бөөрний сайн эм сүгмэлээр голлогч болгож, илчийг сэлбэх эрхтний гар болон шимжүүлэгч цагаан хороор дэдлүүлж, хийг дарах задь, голт бор, хар агарыг, дуслыг зогсоох, хийг дарах хэрээний нүдийг хавсаргасан тул тамиржуулах найрлагын чадал бүрджээ. Зүрхний сайн эм задь, гол судлын сайн эм голт бор, зүрхний халууныг арилгах хар агар зэрэг хийг дарах эмээр хөл болгосон тул голлогч эмийн хийг дарах, илчийг сэлбэх үйлдлийг нэмэгдүүлэн зүрхний хий бүрэлдсэн өвчинд тустай. Цагаан хор, хэрээний нүд, эрхтний гар зэрэг нь төлжүүлж шимжүүлэх, дуслыг нэмэгдүүлэх

бөгөөд дусал цувирахыг зогсоох юм. Хэрэглэх арга, хэмжээ нь насанд хүрэгчдэд өдөрт 1-2 удаа, удаа бүр 1,5-3,0 гр-ыг буцалсан усаар даруулж уулгах буюу махны шөлөөр даруулж уулгана[1].

2. Сүгмэл-7 эм найрлагын хөл эм тус бүрийн судалгаа

Сүгмэл бол гааны язгуурын олон наст өвслөг ургамал болох цагаан сүгмэл *atomum karavank pjerre ex Gagher* буюу жиэн цагаан сүгмэл *Atomum compactum soland.ex Maton* –хатаасан боловсормол жимс мөн. Цагаан сүгмэл голдуу Камбож, Тайван, Вьетнамд гарна. Гашуун, гошгуун амттай, бүлээн чанартай, бөөрний хүйтнийг арилгах, хийг дарах, илчийг сэлбэх, дурыг нээх, бөөлжихийг зогсоох чадалтай тул эмчилгээнд бөөрний сайн эм болгож хэрэглэдэг [2]. Тус эмэнд голдуу дэгдэмхий тос, Са, Мп, К зэрэг органик бус элементийг агуулна. Шингээлтийн системд дэгдэмхий тос нь ходоодны шингэний шүүрэлтийг ахиулан, гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг нэмэгдүүлж, гэдсэнд хурсан хийг хөөх ба гэдэсний эрүүл бус исэлтийг хориглоно. Усан гахайны биеэс зайдуулсан гэдсэнд агшаах нөлөөтэй. 1% уусмал болон дэгдэмхий тос нь хориглох үйлдэлтэй. Үүнээс гадна тус бодист агуулагдах органик бодис ба чанасан шингэнд К, Са, Mg, Zn, Мп зэргийн органик бодис агуулагдаж, ходоодыг чангаруулж, шингээлтийг сайжруулах үйлдэлтэй. Мөн бактерийг эсэргүүцэх үйлдэлтэй [3].

Цагаан хор бол сараанын язгуурын олон наст өвслөг ургамал болох цагаан хор *Polygonum sibiricum Delar.ex Red*, чихэрлэг цагаан хор *Polygonatum cyrtonema Hua* буюу Юнан цагаан хор *Polygonatum kingianum Coll.et Hemsl.* –ийн хатаасан үндэслэг иш мөн. Өвөр монгол, зүүн хойд орон, хөбэй, шанши, ниншан, гансу, хөнэн шандун, ниэнин мужид гарна. Амтлаг, эхүүн, гашуун амттай. Бүлээн чанартай. Эмчилгээнд оруулахдаа үнээний сүүнд чанаж хэрэглэдэг.

Шимжүүлэх, хүчжүүлэх, өгөр шар усыг арилгах чадалтай. Химийн бүрэлдэхүүнд нь олонч чихэр агуулдаг бөгөөд, дархлааг дээшлүүлж, өтлөхийг удаашруулах, цусны чихэрийг бууруулах, микробыг эсэргүүцэх, зүрхний хэмнэлийг түргэсгэх, цусны өөхийг бууруулах ба лугших судал хатуурахыг эсэргүүцэх, цусны даралтыг бууруулах, титэм судлыг тэлүүлэх ба зүрхний булчинд цус дутахыг эсэргүүцэх зэрэг эм зүйн үйлдэлтэй [3] болохыг судалгаагаар нотолжээ.

Эрхтний гар бол цахирмаагийн язгуурын олон наст өвслөг ургамал болох улаан цахирмаа *Gymnadenaconopsea R.Br.*-ийн хатаасан төмслөг иш мөн. Өвөр монгол, зүүн хойд орон, умард орон, баруун хойд орон, шиян, юнан, түвдэд гарна. Амтлаг эхүүн амттай, бүлээн чанартай, эмчилгээнд хэрэглэхдээ үнээний сүүнд нэвтэртэл чанаж хэрэглэдэг. Тунгалаг зэрэг долоон тамирыг сэлбэж, дусал цувирахыг зогсоох, шимжүүлэх чадалтай. Голдуу амин хүчлийн төрөл, олонч чихэр агуулж, зүрхний булчинг хамгаалах, цусны даралтыг тогтворжуулах, элэгний ажиллагааг сайжруулах, үрэвслийг эсэргүүцэх, бактерийг эсэргүүцэх, ханиадыг зогсоох, цэрийг ховхлох зэрэг эм зүйн үйлдэлтэй байдаг [3].

Задь бол задийн язгуурын ургамал болох *Myristica franrans Houtt.*-ийн модны хатаасан боловсормол үрийн цөм болно. Химийн бүрэлдэхүүнд тосонд уусамхай нэгдэл 24 зүйл агуулагдах ба гошгуун амттай, бүлээн чанартай. Хийг дарах, илчийг сэлбэх, идээг шингээх, дурыг нээх чадалтай. Эм зүйн туршилтаар минчүүрүүлэх (мэдээ алдуулах), тайтгаруулах, исэлдэлтийг эсэргүүцэх үйлдэлтэй болно. Маш сүрхий минчүүрүүлэх болон элэгний хувиралтыг буй болгох хорт назгай үйлдэлтэй [10].

Голт бор бол галбираг язгуурын ургамал болох голт бор *Eugenia caryophyllata Thunb.*-ийн хатаасан цэцгийн цомирлог болно. Гошгуун,

өчүүхэн гашуун амттай, бүлээн чанартай. Хүйтэн хийг арилгах, хоолойд туслах, илчийг сэлбэх, идээг шингээх, дурыг нээх, хорыг тайлах, гүвдрүүг тууруулах чадалтай. Химийн бүрэлдэхүүнд нь дэгдэмхий тос болно. Тайтгаруулах, өвдөхийг зогсоох, микробыг эсэргүүцэх, ходоодны шархлааг аниулах, цус ээдрэхийг эсэргүүцэх, зүрхний булчинд кальцийн хэмжээг бууруулах, хүчилтөрөгч дутагдахыг эсэргүүцэх зэрэг эмийн зүйн үйлдэлтэй [3].

Агар бол бэлэгт цээны язгуурын ургамал болох хар агар буюу цагаан агар *Aquilaria sinensis* (Lour.) Gilg.-ийн хар өнгөт давирхай агуулагддаг мод болно. Гошгуун, гашуун амттай, сэрүүн, хүнд, тослог, хуурай, мохдог, эелдэг чанартай. Хийг дарах, халууныг арилгах, амьсгаадахыг дарах, хатгалгыг дарах чадалтай. Үүнд голдуу дэгдэмхий тос агуулж, төв мэдрэлийг хориглох, цулгуй булчинг агшаах, нарийн гэдэс хоолойн гөлгөр булчинг агшихыг хориглоно. Бензинээр гарган авсан бодис нь халууныг бууруулах үйлдэлтэй [3].

3. Сүгмэл-7-ийн эмчилгээний тухай судалгаа

Сарын хир ирэх үед өвдөхийг эмнэн засах [4], хятад монгол эмнэлэгийн туршлагаар сарын хир ирэхэд өвдөхийг эмнэн засах болно. Мин лан судалснаар Сүгмэл-7-гоор гол болгон бусад эмтэй хавсран сарын хир ирэхэд өвдөхийг зогсоох 60 жишээ өвчтөнийг эмнэн зассан туршлагатай [5], Ван шу лан нарын судалгаагаар төлжүүлэгч-7 хүүхэн хэвтэш дотор бүрхэвчийн орон нь шилжсэн чанартай сарын хир ирэхэд өвдөхийг эмнэн засаад маш сайн үр дүнг олсон байна [6]. Сарын хир тэгш бусыг эмнэн зассан Бай мэй рүн нар Сүгмэл-7 гол гол болгон бусад Монгол эм найрлагыг хавсруулан сарын хир тэгш бусыг эмнэн засаад эдгэрэлтийн норм 93,1% хүрсэн байна [7]. Сарантуяа нар Сүгмэл-7-г бусад монгол эм найрлагатай хавсараад сарын

хирийн үечлэлийн хугацаа, сарын хирийн хэмжээ зэргийг засаж шинж тэмдгийг илт сайжруулсан байна [8]. Үүнээс гадна, эмэгтэйн удаан чанартай аарцгийн хөндийн үрэвсэл [9], эмэгтэйн жирэмслэхгүй өвчин [10,11], эмэгтэйн сарын хир зогсох үеийн ерөнхийлсөн чанартай өвчин [12]-д эмнэн засах ач тус нь маш сайн болно.

4. Сүгмэл-7-ийн эм зүйн үйлдлийн судалгаа

Зу үй мин нарын судалснаар Сүгмэл-7 нь туулайн биеэс зайдуулсан гэдэсний гөлгөр булчинд маш сайн сулруулах үйлдэлтэй бөгөөд бас исэлдэхийг эсэргүүцэх үйлдэлтэй [13]. Ван шу лан нар судалснаар Сүгмэл-7 нь хулганы хүчилтөрөгч дутахыг тэсвэрлэх чадварыг дээшлүүлэх, усанд сэлэлтийг уртасгах, исэлдэхийг эсэргүүцэх, том хулганы шээсний хэмжээг нэмэгдүүлэх зэрэг эм зүйн үйлдэлтэй болохыг мэдсэн байна [14]. Зу жүн хуан нарын судалснаар Сүгмэл-7 нь хүүхэн хэвтэшийн цулгуй булчинд өвдөхийг зогсоох үйлдэлтэй [15], Ху пин нар судалснаар төлжүүлэгч сүгмэл-7 нь биеэс зайдуулсан хүүхэн хэвтэшийн гөлгөр булчингийн хэмнэлт болон агшилтыг хориглох үйлдэлтэйг нотолсон байна [16].

5. Сүгмэл-7-гийн чанарын судалгаа

Багана нар нимгэн үеийн хроматографийн аргаар сүгмэл-7 дахь сүгмэл, агар, задь, голт борд чанарын шинжилгээ хийж, хийн фазт хроматографийн аргаар голт борын дотор агуулагдах голт борын фенолын агуулагдацыг хэмжсэн байна [17], Сараа нар нимгэн үеийн өнгө жагсаалын аргаар сүгмэл-7 агуулагдах цагаан сүгмэл, агар, задь, голт бор, цагаан хор, хэрээний нүд, эрхтний гарт чанарын шинжилгээ хийсэн [18]. Жан ян нар нимгэн давхаргын өнгө жагсаалын аргаар сүгмэл-7 эм найрлага дахь хэрээний нүд, голт борын чанарын шинжилгээ хийж мөн голт борын фенолын хэмжээг тогтоожээ [19]. Фен И Тан

нар хийн фазт хроматограф ашиглан сүгмэл-7 дахь тосны агуулагдацыг хэмжжээ [20]. Шиу Хуа нар нимгэн үеийн хроматографийн аргыг хэрэглэж сүгмэл-7 дахь цагаан хор болон гол борын чанарын шинжилгээ [21,22] , HPLC аргаар сүгмэл-7 дахь голт борын фенолын агуулагдацыг хэмжсэн [23] байна.

Дүгнэлт

Ном материал болон эрдэм шинжилгээний сурвалж тэмдэглэлд үзвэл Монгол эм найрлага сүгмэл-7 –ийн хөл эмийг нэгэнтээ химийн бүрэлдэхүүн, эм зүйн үйлдэл зэрэг талаар бүрэн судалсан байна. Жор найрлага хувьд чанарын судалгаа, эм зүйн үйлдлийн судалгаанд хүчилтөрөгч дутахыг тэсвэрлэх чанарыг дээшлүүлэх, усанд сэлэхийг уртасгах, исэлдэхийг эсэргүүцэх судалгаа хийгдсэн боловч түүний үйлдэл үзүүлэх жам ёс, эмчилгээний хэрэглээг бүрэн тусгасан эм зүйн үйлдлийн судалгаа явагдаагүй байна. Үүнээс гадна нэн чухал болох нь монгол анагаах ухааны эмчилгээний өвөрмөц үйлдэл болох нэмэр эм тавьж өвчнийг засах, эмт бодисыг хавсруулан хэрэглэх зэрэг онцлогийг тусгасан эм найрлагын үйлдлийг судалсан судлагаа хараахан байхгүй байна.

Ном зүй

1. Багана. Монгол анагаах ухааны эм найрлагын судлал [M]. Хөх хот. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 2007, 4: 278-279.
2. Ван эрдэнэ. Монгол эмийн судлал [M]. Шиян: Лионины үндэстэний хэвлэлийн хороо. 2000, 6:97-98.
3. Ван шиу лан. Монгол эмийн эмийн зүйн судлал [M]. Хөх хот:Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 2006, 6-67
4. 任磊, 莫日根巴图. 中蒙医结合治疗原发性痛经疗效观察. [J].中国民族医药杂志, 2011, (3) 18-19.
5. 明莲. 蒙医治疗痛经60例体验[J].中国民族医药杂志, 2004 (2):11.

6. 王寿芳. 暖宫气味丸治疗子宫内膜异位症痛经疗法 [J]. 浙江中西医结合杂志. 2012, 22 (2) 116-117.
7. 白金荣, 白银荣, 斯琴其木格. 蒙医辩证论治月经不调58例临床报告[J].中国民族医药杂志, 2007, (1):6 -7.
8. 萨仁图雅, 吴满喜. 蒙医药治疗月经不调48例临床观察[J].中国民族民间医药, 2013,12 (1): 8.
9. 萨仁高娃. 苏格木勒-7为主治疗慢性盆腔炎31例疗效观察[J].中国民族民间医药杂志, 1996 (21) : 20.
10. 达布, 希拉图. 蒙医治疗女性不孕症[J]. 中国民族医药杂志, 2005, 5- 6.
11. 岗敖其尔, 包金荣. 蒙药苏格木勒-7 加沙温-13 味治疗不孕症例 [J]. 2010,7 (5):37.
12. 赵玉明, 纳顺达来. 蒙药暖宫七味散治疗更年期综合症临床观察[J].中国民族医药杂志, 2007 (1): 8.
13. 刘和莉, 吴海军, 徐继辉, 等. 暖宫七味胶囊对兔离体肠平滑肌的作用[J].包头医学院学报, 2002,18 (2):91-92.
14. 王秀兰, 王欢, 吴龙堂. 蒙药苏格木勒-7药效研究 [J]. 中国民族医药杂志, 2006,5:53-54.
15. 赵中华, 王玉英, 包桂兰, 等.暖宫七味丸的药效学研究 [J]. 现代中西医结合杂志, 2008,17 (8): 1150-1151.
16. 郝奋, 杨玉梅, 应康, 等暖宫七味胶囊与水丸对大鼠离体子宫的作用比较包头医学院学报, 2002,18 (7):180-181.
17. 巴根那,王青虎,宝音朝格拉. 蒙药苏格木勒-7味丸质量标准研究 [J].中药材, 2008, 31 (1): 137-138.
18. 莎日娜, 巴俊杰, 乌兰辉. 蒙药苏格木勒-7的薄层色谱鉴别 [J].中国民族医药杂志, 2007, 5:41-42.
19. 张妍, 李树庆. 暖宫七味丸质量标准研究 [J]. 中国民族医药杂志, 2009, 6:52-53.
20. 冯义廷. GC 法测定暖宫七味散中桉油精的含量[J].河南中医, 2009, 29 (7): 708-709.
21. 徐华, 高钢. 暖宫七味丸的薄层色谱鉴别 [J].北方药学, 2014, 11 (2) 3.
22. 候峰, 施法, 田金苗, 等. 暖宫七味丸的质

量标准研究[J].中国药事, 2012, 26 (10) 1119-1121.

23.吴军侠, 赵红侠. 高效液相色谱法测定蒙药暖宫七味散中丁香酚含量测定[J].中国药业 2010, 19 (5): 31-32.

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
АУ-ы доктор, дэд профессор Х.Туул*